

Үнэт цаас гаргагчийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан санхүүгийн тайлан, өр, зээлийн талаархи мэдээ:

Санхүүгийн үзүүлэлтүүд

Компанийн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлангуудын хураангуйг доорхи хүснэгтэд харуулав.

Хүснэгт

Тайлан тэнцэл

	/Мянган төгрөг/		
	2005	2006	2007. II
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө	440	2,295	6,291
Мөнгөн хөрөнгө	440	2,295	3,760
Авлага		6,733	2,523
Эргэлтийн бус хөрөнгө	1,385,332	21,914	999,309
Тавилга, эд хогшил	19,147	28,406	28,599
Элэгдэл	(1,892)	(6,526)	(9,004)
Биет бус хөрөнгө	37	34	999,309
Нийт хөрөнгө	17,731	24,210	1,005,600
Эх үүсвэр			
Нийт өр төлбөр	27,266	33,799	35,550
Дансны өглөг	27,000	29,805	29,812
ХАОАТ-ын өглөг	28	89	922
НӨАТ-ын өглөг	(41)	3,136	2,742
ЭМНД-ын шимтгэл	280	767	2,074
Эздийн өмч	(9,535)	(9,588)	970,050
Хувийн	5,000	5,000	5,000
Дахин үнэлгээний нөөц			979,680
Хуримтлагдсан ашиг/алдагдал	(14,535)	(14,588)	
Тайлангийн үеийн	(14,535)	(53)	(42)
Өмнөх үеийн	0	(14,535)	(14,588)
Нийт эх үүсвэр	17,731	24,210	1,005,600

2005 оны эцсээс 2007 оны 2 дугаар улирлыг хүртлэх хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 56 дахин өсчээ. Дансны өглөгийн хувьд богино хугацаат нийгмийн даатгалын болон хүн амын орлогын албан татварын өглөг байгаа бөгөөд өр төлбөр эзэмшигчдийн өмчийн 0.47 хувийг эзэлж байгаа нь Оллоо ХХК өр төлбөрийн хувьд бага байна. Оллоо ХХК нь богино хугацаанд борлуулалтаа нэмэгдүүлэн, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлуудаа хэмнэж чадсанаар ашигт ажиллагаагаа нэмэгдүүлсэн юм.

Орлого үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

	2005	2006	2007. II
Нийт борлуулалт	7,653	61,168	51,495
Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	17,416	44,871	38,706
Нийт ашиг	(9,763)	16,297	12,789
Үйл ажиллагааны зардал	4,783	6,000	12,829
Үйл ажиллагааны ашиг	(14,546)	10,296	(41)
Үйл ажиллагааны бус орлого	12	0	0
Үйл ажиллагааны бус зардал	0	10,340	18
Татварын өмнөх ашиг	(14,534)	(44)	(42)
Орлогын татвар			
Цэвэр ашиг	(14,534)	(44)	(42)

2007 оны 2 дугаар улирлын байдлаар борлуулсан бүтээгдэхүүний өртөг нийт борлуулалтын 76 орчим хувийг эзэлж байна. Нийт зардлын 23 орчим хувийг ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлс болон боловсон хүчин бэлтгэх зардал, 9 хувийг шуудан холбооны зардал, 49 хувийг богино хугацаат зээлийн хүүгийн зардал тус тус эзэлж байна.